



**“УЛААНБААТАР ЧУУЛГА”**

**2019 ОНД**

# **НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХАД:**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тус хөтөлбөрийн:

<b>1.4.1 заалтад нийцүүлэн</b>	<b>Монголын соёл, өв уламжлалыг харуулсан соёлын биет болон биет бус өвийн үзүүлэх тоглолт бүхий бэсрэг концертыг бэлтгэн, гадаадын болон өөрийн орны иргэдэд Улаанбаатар хотыг сурталчлах ажлыг зохион байгуулна.</b>
<b>5.1.2 заалтад нийцүүлэн</b>	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг байгууллагын онцлогт тохируулан боловсруулж, улирал бүр дүгнэж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж ажиллана.
<b>4.3.5 заалтад нийцүүлэн</b>	Аз жаргалтай хот хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа урлагийн бүхий л арга хэмжээнүүдэд хамт олноороо урлагийн байгууллагуудыг манлайлан оролцоно.
<b>1.6.1 заалтад нийцүүлэн</b>	Байрны өмч ашиглалтыг сайжруулах замаар, үргүй зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулж орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлж ажиллана.

**2019 оны жилийн эцсээр 100%-ийн биелэлттэй ажилласан.**

**Мөн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд 18 ажлыг төлөвлөн зохион байгуулж, 100% биелэлтийг хангаж ажилласан.**

Биелэлтийн дэлгэрэнгүй тайлан хариуцагч - дотоод ажил хариуцсан мэргэжилтэн  
Б.Өнөрцэцэг

# *ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН:*

Нийслэл хотыг тойрсон орон нутаг болон Нийслэлийн алслагдсан дүүргийн ард иргэдэд хүрч үйлчлэх замаар орлого нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран “Их хотын аялгуу” тоглолт

Нийслэлийн 9 дүүргийн 3500 гаруй иргэдэд хүрч ажилласан.

Ерөнхий боловсролын сургуулуудийн ахлах ангийн сурагчдад зориулсан “**Үндэсний өв соёлын үнэ цэнийг таниулах нь**”, “**Соёлыг түгээе**” бичил төсөл хэрэгжүүлж байна.

Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Монголын Битбоксын холбоотой хамтран нийслэлийн 60 сургуулийн 6 мянга гаруй сурагч, 21 аймгийн ард иргэдэд хүрч ажиллахаар 2 дахь жилдээ ажиллаж байна



# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Гоцлоочдын уран бүтээл туурвих сэтгэлгээг дэмжиж,  
тайлан тоглолтыг зохион байгуулж ажилласан.



2019 оны 1 сарын 26-нд  
гоцлол дуучин, МУСТА М.Анхтуяа  
“Тэгш дүүрэн жаргалтай яваарай” тоглолт

2019 оны 03 сарын 18-нд  
Гоцлол дуучин, МУСТА  
Ж.Буянтогтох  
“Ижилгүй монгол орон”  
ТОГЛОЛТ



2019 оны 09 сарын 29-нд  
бүжигчин Ж.Номгонмаа  
“Тэргэнцэртэй бүжигчин”  
ТОГЛОЛТ



# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## Тайзнаа тоглосон томоохон тоглолтууд



Жуулчдад зориулсан “Color-s of Mongolia” ардын урлагийн тоглолтыг 6,7,8 дугаар саруудад өдөр бүр 18,00 цагаас тоглож ХЭВШСЭН.



Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулсан “Их хотын аялгуу” тоглолтоо 10 дугаар сарын 18-нд нээж, нийслэлийн 9 дүүргийн иргэдэд хүрч үнэгүй тоглосон.



“Мауглитай танилцсан нь” хүүхлэд зориулсан циркчилсэн тоглолтоо 11 дүгээр сарын 21-нээс эхлэн өөрийн тайзнаа 7 хоног тоглож, хүүхэд багачуудын мэлмийг мялаасан.

# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## Тайзнаа тоглосон томоохон тоглолтууд

УЛААНБААТАР ЧУУЛГА

# Мартын 8

ХАВРЫН УЯНГА  
ТОГЛОЛТ

Тоглолтонд:  
МҮГЖ Г.Хонгорзул  
МҮГЖ С.Ганзориг  
МҮГЖ Б.Батбалд  
МУСТА М.Анхтүхэ  
Хийлч Дээгий  
МУСТА О.Анхчимэг  
МУСТА Ц.Гансүх  
Этник дуучин Д.Шижирмаа  
BEATBOX RAY  
Дуучин Н.Бамбалдорж  
Авъяаслаг Монголчууд шоуны шилдэг оролцогчид  
Бараа, Мийгаа  
Цохивор хөгжимчин Б.Дуулал  
Цохилгоон хөгжмийн хамтлаг  
Үндэсний хөгжмийн ХАНГАРЬД найрал  
Улаанбаатар чуулгын бүжигчид  
УЛААНБААТАР ЦИРК-ийн уран бүтээлчид

УЛААНБААТАР  
ЧУУЛГЫН ТАЙЗНАА  
2019.03.08  
19:00 цагаас

WWW.UBCHUULGA.MN 70118411, 99996615, 80004268 WWW.FB.COM/UBCHUUULGA

3 дугаар сарын 8-нд “Мартын 8” тоглолтонд чуулгын хөгжмийн 3, дууны 3, бүжгийн 3 шинэ бүтээлээс бүрдсэн тоглолтоо үзэгч олондоо өргөн барилаа.

УЛААНБААТАР ЧУУЛГА

ҮНДЭСНИЙ ХӨГЖМИЙН  
ХАНГАРЬД НАЙРАЛ  
ТОЛИЛУУЛЖ БАЙНА

# ХАНГАРЬД НАЙРАЛ

# 10 жил

ХҮНДЭТГЭЛИЙН  
ТОГЛОЛТ

2019.12.06  
19:00

УЛААНБААТАР ЧУУЛГЫН ТАЙЗНАА

ЭНЭХҮҮ ТОГЛОЛТОНД МОНГОЛЫН БОЛООД ДЭЛХИЙН ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧДЫН ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮД ЭГШИЛГЭХЭЭС ГАДНА АВЬЯАСЛАГ МОНГОЛЧУУД ШОУНЫ ДЭД БАЙРЫН ШАГНАЛТ Х.БАРХҮҮ, Б.МЯГМАРЦЭРЭН, ОХИДЫН ХАМТЛАГ БОЛОН АВЬЯАСЛАГ ЗАЛУУ ХӨГЖИМЧИД ШИЛДЭГ БҮТЭЭЛЭЭ ТОЛИЛУУЛНА.

УЛААНБААТАР ЧУУЛГАД ТАВТАЙ МОРИЛНО УУ.

WWW.UBCHUULGA.MN 70118411, 99996615, 80060569 WWW.FB.COM/UBCHUUULGA

Улаанбаатар чуулгын Үндэсний хөгжмийн ХАНГАРЬД найрал үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан тоглолт 2019-12-20нд тоглосон.

# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## 2019 онд байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл болох:

- Урлагийн тоглолт - 322 тоглолт
- Тайзны түрээсийн үйлчилгээ - 188 ажил

### Урлагийн тоглолт - 322

1	Ерөнхийлөгч	1
2	Ерөнхий сайд	4
3	Шадар сайд	1
4	УИХ	11
5	Бусад яамдууд	17
6	НИТХ	40
7	НЗДТГ, харьяа агентлагууд	126
8	НСУГ	9
9	Гадаад тоглолт	19
10	Улаанбаатар чуулга	113

“Аз жаргалтай хот” хөтөлбөрийн хүрээнд

- Улаанбаатарын өвлийн наадам
- Гэр бүлийн баяр, Цасны баяр
- Номын баяр
- Нийслэлийн нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаа
- “Дээлтэй монгол наадам”
- “Даншиг наадам хүрээ цам”
- Нийслэлийн бүтээн байгуулалтын шагнал гардуулах “Garuda” ёслол
- Бүргэдийн баяр
- “Улаанбаатар Марафон”
- “Талын салхи” зэрэг томоохон ажлуудыг дурдаж болно.

Нийт оролцсон уран бүтээлчдийн тоо: **4.383**  
Нийт үзэгчдийн тоо: **26.468.698**


# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## Тайзны түрээсийн үйл ажиллагаа – нийт 188 ажил

Улирал	2018 он		2019 он	
	Үйлчлүүлсэн байгууллагын тоо	Үйлчлүүлсэн үзэгчдийн тоо	Үйлчлүүлсэн байгууллагын тоо	Үйлчлүүлсэн үзэгчдийн тоо
I	35	14310	29	11866
II	79	32760	45	12850
III	20	9610	44	3949
IV	50	10350	70	26760
<b>Нийт</b>	<b>184</b>	<b>67030</b>	<b>188</b>	<b>55425</b>

2019 оны тайзны ажлын тоо

2018 оны тайзны ажлын тоо



2018 оны тайзны ажлын тоо

184


2019 оны тайзны ажлын тоо

188

■ Series1

2019 оны үйлчлүүлэгчдийн тоо

2018 оны үйлчлүүлэгчдийн тоо



2018 оны үйлчлүүлэгчдийн тоо

67030

2019 оны үйлчлүүлэгчдийн тоо

55425

■ Series1



# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:


**Тайзны түрээсийн үйл ажиллагаа – нийт 188 ажил**

Нийт ажлын тоог ангилбал:	188
Нийслэлийн засаг даргын Тамгын газар	8
Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	6
Нийслэлийн соёл урлагийн газар	3
Бартерын гэрээтэй телевиз, агентлаг, про-шн	11
Улаанбаатар чуулга	84
Хандивын тоглолт	4
Дэмжиж ажилласан ажлууд	18
Төлбөрт болон гэрээт ажлын тоо	54

**Тайзны түрээсээр төвлөрүүлсэн орлого /6 жилээр/**

2014 он	64,200,000
2015 он	66,200,000
2015 он	100,074,999
2017 он	84,000,000
2018 он	92,900,000
2019 он	100,864,000

**Тайзны түрээсээр орлого төвлөрүүлэлт /сүүлийн 6 жилээр/**



*БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*

**Төсөв санхүү**

**Улаанбаатар чуулга 2019 онд:**

Ажилчдын цалин, НДШ зардалд **638,4** сая төгрөгийн санхүүжилтийг нийслэлийн төсвөөс авч,


Нийслэлийн төсөвт **160.0** сая төгрөг төвлөрүүлж урсгал зардлаа санхүүжүүлж ажилласан.

Орлогын төрөл	Ажлын тоо	Мөнгөн дүн
Тайзны түрээсийн орлого	188	100.864.000
Урлагийн тоглолтын орлого	322	36.798.250
Бусад орлого		22.321.500
ДҮН		159.983.750

# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## Төсөв санхүү

Төлөвлөгөө, гүйцэтгэл харьцуулсан график-сүүлийн 5 жилээр



■ Төлөвлөгөө

2014 он

2015 он

2016 он

2017 он

2018 он

2019 он

102.0

120.0

148.0

168.0

178.0

178.0

■ Гүйцэтгэл

84.7

89.8

130.0

130.7

154.1

160.0

## Харьцуулсан судалгаа:

№	Байгууллагын нэр	Ажиллагс-дын тоо	Нийт төсөв	Төсвөөс санхүүжих	Өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	Үйл ажиллагааны орлогын нийт төсөвт эзлэх хувь
1	Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр	285	3.6 тэр бум	3.6 тэр бум	-	9 % / 0%
2	Улсын Драмн Эрдмийн Театр	129	1,7 тэрбум	1,7 тэрбум	-	20 % / 0%
3	Дарханы “Залуучууд” Театр	99	989 сая	989 сая	-	5.8 % / 0%
5	Үндэсний Урлагийн Их Театр	189	2.5 тэрбум	2.5 тэрбум	-	14.4 % / 0%
6	Цэргийн Дуу бүжгийн эрдмийн чуулга	179	1.9 тэрбум	1.9 тэрбум	-	3.7 % / 0%
7	<b>“Улаанбаатар” чуулга</b>	<b>62</b>	<b>816,4 сая</b>	<b>638,4 сая</b>	<b>178,000.0</b>	<b>21,8 %</b>

# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## Архив, албан хэрэг хөтлөлт

- 2019 оны 1-р улиралд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 81 хадгаламжийн нэгж хүлээн авах хуваарь гарган батлуулсан.

### Хуваарийн дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	41 хадгаламжийн нэгж
Маркетингийн менежер	10 хадгаламжийн нэгж
Хүний нөөцийн менежер	14 хадгаламжийн нэгж
Санхүү	24 хадгаламжийн нэгж
Архивын эрхлэгч	12 хадгаламжийн нэгж

#### Архивт:

- Байнга хадгалах 2018 оны 36 хадгаламжийн нэгж,
- Түр хадгалах 41 хадгаламжийн нэгж,
- 70 жил хадгалах 3 хадгаламжийн нэгжийг тус тус хүлээн авлаа.

# БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

## Архив, албан хэрэг хөтлөлт



Байгууллагынхаа захирамжлалын баримтаар төрийн архивт иж бүрэн нөхөн бүрдүүлэлт хийж батламж авсан.



Нийслэлийн архивын газарт 2019 оны 04 сарын 02-нд архивын тухай хуулийн 23.1.9. дэхь заалтын дагуу төрийн архивт баримт шилжүүлэх хугацаа болсон 2011-2014 оны 131 баримтыг хүлээлгэн өгч актаа хүлээн авсан.

**Архив, албан хэрэг хөтлөлт**

**2019 оны АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГ-ээр  
89,6 оноогоор “ХАНГАЛТТАЙ” үнэлгээ авсан.**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны А/518 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай захирамжийн дагуу байгууллагын даргын 2019 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/13 тоот тушаалаар байгууллагын комисс байгуулан төлөвлөгөө боловсруулан ажилласан.

1. Байгууллагын архивын ажлын зохион байгуулалт
2. Байгууллагын зорилт, чиг үүрэг, ирээдүйн дүр төрхийг тодорхойлон тогтоосон байдал
3. Албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллага, удирдлага, ажилтнуудын хүлээх үүрэг түүний хэрэгжилт
4. Байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлэх гэсэн 4 чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажилласан.

## ЧУУЛГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО:

НЗД-ын 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/946 дугаар захирамжаар батлагдсан орон тоо “62”.

№	<b>2019 оны жилийн эхэнд байсан албан хаагчдын тоо</b>	<b>62</b>
1	Ажлаас чөлөөлөгдсөн	10
2	Ажлаас түр чөлөөлөгдсөн	1
3	Ажилд эргэн томилогдсон	1
4	Ажилд үндсэн ажилтнаар шинээр томилогдсон	9
5	Түр орлон гүйцэтгэгч	5
6	Хүүхэд асрах чөлөөтэй	3
7	Жирэмсний амралттай	3
	<b>2019 оны жилийн эцсээр :</b>	<b>60</b>

### Хүний нөөцийн судалгаа /товч/

2019 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт 60 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 76,3 хувь нь буюу 45 албан хаагч 3-аас дээш жил тус чуулгад ажиллаж байгаа болно.

### Боловсролын түвшин

	Ажилтны тоо	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол	Техник, мэргэжлийн	Бакалавр	Магистр	Доктор
Нийт ажилтан:	60	0	0	1	5	30	24	0
Эрэгтэй ажилтан:	32	0	0	1	4	16	11	0
Эмэгтэй ажилтан:	28	0	0	0	1	14	13	0



# ЧУУЛГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО:

## Зэрэг ахиулж суралцаж байгаа албан хаагчид:

Докторантур	-	<u>Хос мэргэжил эзэмшихээр</u>	
Магистрантур	3	Суралцаж байгаа	3
Бакалавр	5	Суралцаж төгссөн	3

<u>Албан хаагчдын дундаж нас:</u>	Ажилтны тоо	Дундаж наслалт
Нийт ажилтан:	60	33.3
Эрэгтэй ажилтан:	32	33.44
Эмэгтэй ажилтан:	28	33.79

## Гавьяа шагнал:

53 албан хаагч – 88,3%

1/ Жуух бичиг – 15

2/ МУСТА – 25

3/ Гавьяат жүжигчин – 2

4/ Нийслэлийн тэргүүний ажилтан – 10

5/ Нийслэлийн хөдөлмөрийн аварга - 1

## Зохион байгуулалтын анги

1	Захиргаа	9
2	Тайз үйлдвэрлэлийн анги	8
3	Дуу анги	9
4	Хөгжим анги	22
5	Бүжиг анги	12

# ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД:



## Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн зорилго:

Олон улсын жишиг шаардлага, төрийн албаны шинэтгэлийн бодлогод нийцүүлэн эдийн засгийн хөгжлийг үр ашиг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн хүний нөөцийг хөгжүүлэн бэхжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

## Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн стратегийн зорилтууд

1. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны шинэчлэлд нийцүүлэн ажиллах хүчний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох,
2. Хүний нөөцийн нийлүүлэлтийн эх үүсвэрийг тодорхойлж, хуулийн дагуу ил тод, шударгаар бүрдүүлэх,
3. Ажлын шаардлага, мэдлэг, ур чадварын түвшинг харгалзан хүний нөөцийг оновчтой, зөв байршуулах,

# ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД:

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (Уран бүтээлчдийн ур чадварын нээлттэй сонгон шалгаруулалт)

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 4 сарын 5-ны өдөр уран бүтээлчдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй хийсэн. Үүнд гаднаас 33 уран бүтээлч, чуулгын 29 албан хаагч шалгаруулалтад оролцсон.

Тус шалгаруулалтын шүүгчээр:

- МУГЖ, УДБЭТ-ын дарга, дуучин Ц.Төвшинтөгс
- МУГЖ, дуучин Ц.Үенч
- Улсын филармонийн ерөнхий удирдаач,  
МУСТА , Д.Нямдаш,
- Монгол Улсын Консерваторийн бүжгийн багш,  
МУСТА Н.Эрдэнэбаяр,
- Монгол Улсын Соёл Урлагийн Их сургуулийн  
багш, профессор Д.Ариунаа



### Сургалтын хөтөлбөр нь:

- Анхан шат /танилцуулах сургалт/,
- Дунд шат /зэрэг дэв горилох туршлагажуулах сургалт/
- Ахисан шат /ур чадварыг нэмэгдүүлэх сургалтууд/
- Ерөнхий сургалт /ерөнхий мэдээлэл өгөх сургалт/

Төрийн үйлчилгээний болон төрийн үйлчилгээ соёл урлагийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох;

Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг үе шаттайгаагаар тасралтгүй дээшлүүлэх замаар мэргэшсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх;

Мэргэжлийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр бусад байгууллага болон гадаад, дотоодын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

**2019 онд Дотоод сургалт 5, гадаад сургалт 14, нийт 19 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 364 албан хаагч хамрагдсан байна.**

- “Нийслэлийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхижуулах” сургалт
- ХБНГУ-ын бүжиг дэглээч Фолкер Айзенах МАСТЕР КЛАСС сургалт
- “Монголын Улсын Зохиогчийн эрхийн тогтолцоог сайжруулах нь” Үндэсний семинар
- “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл мэндийн зөв дадал, зуршил” сургалт
- “Гэр бүлийн боловсрол” сургалт
- Гамшгаас хамгаалах анхан шатны дадлага сургалт
- Архидалт ыа бусад донтолт сургалт
- Ажлын байран дах эрүүл зөв хооллолт зэргийг дурдаж болно.

# ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД:

Албан хаагчдын нийгмийн  
баталгааг хангах хөтөлбөр:

## Албан хаагчдын ажлын байрны нөхцлийг сайжруулах чиглэлээр

Хөтөлбөрийг албажуулсан шийдвэрийн дугаар	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, батлагдсан төсөв	Хөтөрлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан зардал /төгрөгөөр/	хэрэгжилт хувиар
<b>Улаанбаатар чуулгын даргын 2015.09.25-ны А/13 тоот тушаал</b>  <b>/Шинэчилсэн: 2019/</b>	Албан хаагчдын ажлын ур чадвар, үр дүнг үнэлэн шагналд тодорхойлж шагнуулав.	1,3 сая	100%
	Нэг удаагийн тэтгэмж, /сая төгрөг/	0,8 сая	100%
	Хөгжим тоног төхөөрөмжийн запас сэлбэг /сая төгрөг/	7,8 сая	100%
	Засвар үйлчилгээ /сая төгрөг/	13,9 сая	100%
	Урсгал засвар /сая төгрөг/	2,1 сая	100%
	Эд хогшил худалдан авах зардал /сая төгрөг/	7,8 сая	100%
	Бичиг хэрэг /сая төгрөг/	1,4 сая	100%
	<b>Бүгд /сая төгрөг/</b>		<b>35,1 сая</b>

# ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД:

Албан хаагчдын нийгмийн  
баталгааг хангах хөтөлбөр:

Уран бүтээлчийн нэр	Албан тушаал	Шагналын нэр	Огноо
Б.Баатархүү	Орлогч дарга	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
Д.Ганзол	Морин хуур хөгжимчин		
Ж.Номгонмаа	Бүжигчин		
Б.Гэрэлтуяа	Шанз хөгжимчин		
Ц.Гансүх	Дуучин		
Н.Бямбадорж	Дуучин		
Д.Шижирмаа	Дуучин		
И.Эгэлханд	Ятга хөгжимчин		
Д.Цэвэлсүрэн	Морин хуур хөгжимчин		
Б.Бат-Өрнөх	Морин хуур хөгжимчин		

## **4 уран бүтээлч “Нийслэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр**

1. Их хуур хөгжимчин Б.Эрхэмбаяр
2. Морин хуур хөгжимчин Д.Ганзол
3. Шанз хөгжимчин Б.Гэрэлтуяа
4. Ятга хөгжимчин И.Эгэлханд,

## **2 уран бүтээлч Нийслэлийн засаг даргын “Жуух бичиг”-ээр**

1. Морин хуур хөгжимчин Б.Бат-Өрнөх
2. Морин хуур хөгжимчин Д.Цэвэлсүрэн

## **Нийслэлийн Соёл урлагийн газрын өргөмжлөлөөр**

Морин хуур хөгжимчин Ч.Адарбилгүүн, Г.Энхбат, их хуур хөгжимчин Г.Бат-Өлзий

# ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД:


Албан хаагчдын нийгмийн  
баталгааг хангах хөтөлбөр:

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор:

1. Лабораторийн шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын гэрээт байгууллага болох "Өнөр Үжин" ХХК-нийн лабораторитой хамтран цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ болон зүрхний цахилгаан бичлэг, хэвлийн хөндийн ЭХО гэсэн 5 төрлийн шинжилгээг хийлгэсэн.

2. Шинжилгээний хариу гарсны дараа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг Этүгэн Их сургуулийн эмч нарын багтай хамтран зохион байгуулж, 9 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарт нийт албан хаагчид үзүүлж, нэгдсэн дүгнэлт хийлгэсэн.

3. Гурав дах шатны үйл ажиллагаа болох албан хаагчдад эрүүл мэндийн талаар мэдлэг олгох сургалтыг Consumer Education Center байгууллагатай хамтран 2019 оны 6 дугаар сарын 18-нд "Ажлын байран дах хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв, дадал зуршил" сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа.



***ӨМНӨХ ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГЭЭС  
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ:***

2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээний дүнд тус чуулга нь “**ХАНГАЛТТАЙ**” үнэлгээ авсан бөгөөд ажлын хүрээнд анхаарч ажиллах 8 заалт бүхий зөвлөмж ирсний дагуу төлөвлөгөө гаргаж, ажилласан.

1	2018 онд “Хариуцлагын жил”-ийн ажлын хүрээнд байгууллагын ажилд тогтоосон сахилга хариуцлага, дэг журмыг 2019 оны үйл ажиллагаандаа хэвшил болгох	Тус журмын 1 дүгээр хавсралтаар баталсан хуваарийн дагуу, холбогдох газруудад тайлан мэдээг хүргэж ажиллана.	100
2	ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулж, үр дүнтэй дуусгах.	Тайлан мэдээ гаргахдаа тус хавсралтуудыг мөрдөн ажиллана.	100
3	Төсвийн сахилга бат, хариуцлагыг чанд сахиж, тэвчиж болох бүх зардлыг хэмнэх	Байгууллагын санхүүгийн төлөвлөгөөг гарган, зардал хэмнэж ажиллана.	100



***ӨМНӨХ ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГЭЭС  
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ:***

4	<p>Байгууллагын үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, ажилчин, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулан, нийгмийн баталгааг нь бэхжүүлэх чиглэлээр тодорхой, үр дүнтэй ажил зохион байгуулах</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, ажилчин, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулан, нийгмийн баталгааг нь бэхжүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллана</p>	100
5	<p>Байгууллагын мэдээлэл, шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ил тод нээлттэй болгох</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, хэвлэл мэдээллийн сонгогдсон бүх сувгаар чуулгын үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийг авах боломжтой болсон.</p>	100
6	<p>Засгийн газраас зарласан “Иргэн төвтөй төрийн үйлчилгээний жил” нийслэлээс зарласан “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн хүрээнд батлагдсан төлөвтөгөөнд тусгасан арга хэмжээ, хийгдэх ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлэх</p>	<p>“Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн ажлын хүрээнд соёл урлагийн цогц арга хэмжээ зохион байгуулж Улаанбаатар хотын нэрийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.</p>	100
7	<p>Байгууллагын батлагдсан орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангахад анхаарч ажиллах</p>	<p>Үргүй зардал буурч, төсвийг хэмнэлт гарсан.</p>	100
8	<p>Албан хаагчдын боловсруулсан баримт бичигт “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг” MNS 5140:2011 стандарт мөрдөж хэвших</p>	<p>Дээрх стандартуудыг мөрдөж, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмж, гарын авлагыг судлан архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.</p>	100

## *НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГААС ӨГСӨН ЦАГ ҮЕИЙН ҮҮРЭГ ДААЛГАВАР, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ:*

- 2019 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр “**90 минутын их цэвэрлэгээ**”- Туул голын эргийг тус чуулгын албан хаагчид цэвэрлэж тайлан мэдээг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Албанд хүргүүлсэн.
- 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр НЗДТГ-аас ирсэн 02-05/1689 тоот албан бичгийн дагуу “**Бүх нийтээр мод тарих арга хэмжээ**”-нд чуулгын 57 албан хаагч 285000 төгрөгний хандив өгч оролцов
- 2019 оны 05 дугаар сарын 18-ний өдөр Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Улаанбаатар марафон-2019” үйл ажиллагаанд хамт олноороо идэвхитэй оролцлоо.
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамжаар, 2019 оны “**Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай**” А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, “Нийслэл дүүргүүдийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 10:00 цагаас 12 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цаг хүртэл Улаанбаатар чуулгын дарга Р.Мөнхсайханаар ахлуулсан 35 хүний бүрэлдэхүүнтэй 24 цагийн хариуцлагатай зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

## ДОТООД УДИРДЛАГЫН ERP.ULAANBAATAR.MN СИСТЕМИЙН АШИГЛАЛТ:

- Хүний нөөцийн удирдлага
  - Цаг бүртгэл
  - Өргөдөл, гомдол
  - Edoc
  - Олон нийтийн сүлжээ
  - Үйл явдал
  - Мэдэгдэл зэрэг системүүдийг тогтмол ашиглаж хэвшсэн.
- 2020 онд ажил төлөвлөлт, ажлын хэсэг, хурал, цуглаан, үүрэг даалгавар гэсэн 2 цэсний хэрэглээг тогтмолжуулахаар төлөвлөөд байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлийг 2018, 2019 онтой харьцуулан графикаар үзүүлэв.




# ДОТООД УДИРДЛАГЫН ERP.ULAANBAATAR.MN СИСТЕМИЙН АШИГЛАЛТ:


**eDoc**

2019 онд байгууллагад ирсэн 212, явсан 196 бичгийг бүртгэн дугаар өгч, цаг тухайд нь шийдвэрлэж ажилласан.

**Ирсэн бичиг**



**Явсан бичиг**



**Хариутай ирсэн, явсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гаргаж тайлагнаж баталгаажуулсан.**

# САЛБАРЫН БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД ШИНЭЭР САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ:

- “Анхаа трэйвэл” ХХК, “Үж Хан” ХХК, “Мини Тоувер” ХХК, “Эм Би Зэт Ай” ХХК-тай Нийслэлийн “Улаанбаатар чуулга” хамтран 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 3 сарын хугацаанд өдөр бүр 18 цагаас гадаадын жуулчдад зориулсан ардын урлагийн тоглолтыг өөрийн тайзнаа тоглож хэвшсэн.



- 2019 оны 09 дүгээр сарын 16-26-ний хооронд АНУ-ын элчин сайдын яамтай хамтран монголд анх удаа “Next Level Hip Program” Ве boy сургалтыг 10 хоногийн хугацаатай чуулгын тайзнаа зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү сургалт нь хүүхэд залуучуудын цагийг зөв боловсон өнгөрөөхөөс гадна дэлхийн хэмжээний шинэлэг /DJ, Mc, Vm, Bb, Kn/-гэсэн 5-н урсгалын сургалтыг нэг дор сурч байгаа нь монголын залуучуудад сонирхолтой бас сурч мэдэх зүйл ихтэй сургалт болж байна. Тус сургалтанд чуулгын бүжигчид хамрагдан мөн уран бүтээлч нартай хамтран шинэлэг аяыг эгшиглүүлсэн байна.



## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:

Нийслэлийн Улаанбаатар чуулга үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа болон тоглолтуудын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхдээ тухайн мэдээллийг тогтмол өөрийн вэб сайт, гадаа гудамжны ЛЕД дэлгэц, телевизийн мэдээ мэдээллийн суваг болон social media-аар тасралтгүй түгээдэг. Бидний бэлтгэсэн мэдээлэл дунджаар 20 000 гаруй хүнд тогтмол хүрдэг.

Хүний нөөцийн  
ил тод байдал

Санхүүгийн  
ил тод байдал

Үйл ажиллагааны  
ил тод байдал



shutterstock.com • 593204357



Улаанбаатар чуулгатай хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагууд:



ww.UPDOWN.mn PUBLIC.MN



## *МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:*

### **Хүний нөөцийн ил тод байдал**

- Улаанбаатар чуулгын албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллахыг албан хаагч нарт анхааруулж ажилласан.
- Ар гэрт нь гачигдал гарсан, бага орлоготой албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж болгон нийт 4 албан хаагчид 800,000 төгрөгийг олгосон.
- Хүүхдийн баяр, Шинэ жилийн баяраар албан хаагчдын 0-14 насны нийт 70 хүүхдэд бэлэг өгсөн.
- БСШУСЯ-ны Соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг, Жуух бичгээр шагнагдсан 10 албан хаагчид шагналын дагалдах мөнгөн шагналыг тушаалаар олгосон.
- “Ub ensemble staff” группийг Facebook дээр ажиллуулж мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь хүргэж ажиллаж байна.
- Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн мэдээллийн системд албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулав.
- Шаардлагатай байгаа ажлын байранд тухай бүр байгууллагын веб, болон сошиал хуудсаар, мөн мэдээллийн самбарт ажлын зарыг байршуулан албан хаагчдын нөөцийг бүрдүүлэн ажилласан.

## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:

### Санхүүгийн ил тод байдал



- 2018 онд “Их Наяд” ХХК санхүүгийн тайланд аудит хийж **“ЗӨРЧИЛГҮЙ”** дүгнэлт өгсөн.
- 2019 оны жилийн төсөв, сар улирлын тайлан мэдээ, орлого, зарлага болон холбогдох баримтууд, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын албаны дүгнэлтийг хуулийн хугацаанд нь мэдээллийн самбар болон шилэн данс, байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг цаг тухайд нь хангаж орлого, зарлагын 149 гүйлгээг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [ubchuulga.mn](http://ubchuulga.mn) сайтад байршуулан ажилласан.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

**Маркетингийн менежер**  
**Л.ОДГЭРЭЛ**

2020 оны ... сарын ...-ны өдөр

ТАНИЛЦСАН:

**“Улаанбаатар” чуулгын дарга**  
**Р.МӨНХСАЙХАН**

2020 оны ... сарын ...-ны өдөр

ХҮЛЭЭН АВСАН:

**Архивын эрхлэгч**  
**Б.СУВД-ЭРДЭНЭ**

2020 оны ... сарын ...-ны өдөр

